


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар буюу **22-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 11 аймагт **1234** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ аван.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1234 тохиолдлын 94% /1167/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /66/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Орхон /4/, Өвөрхангай /5/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /1/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **342** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.


22 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.05.18 – 2026.05.30)


2026 оны хорин хоёрдугаар долоо хоногт 44 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 4300 хувиар, 5 жилийн дунджаас 84.9 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.

**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-22 дугаар долоо хоногт** нийт **732** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



2026 оны **хорин хоёрдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **31** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 72.2 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 163 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (22-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	7	13	20
2	Эмийн хордлого	0	11	11
Нийт		7	24	31

Нийт 31 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 11 (35%) нь эмийн хордлого, 20 (65%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 24 (77%) тохиолдол, санаатай хордлого 7 (23%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-oOo-